

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ГАДААДАД ОРШИН СҮУГАА
МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Улаанбаатар хот
2011 он

DDC
323.6'021'517
Г-132

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

ISBN 978-99929-64-75-8

АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгаа бичихэд оролцогчид.....	4
Товчилсон үгийн тайлбар	8
Өмнөх үг.....	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙГ ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА11	
Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын онцлог.....	13
Үдирдлага, зохион байгуулалт.....	13
Ухуулга, сурталчилгаа, сургалт	14
Тооллогын асуулга боловсруулалт, тоолох үе.....	15
Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийг тоолоход хэрэглэсэн зарим ойлголт, тодорхойлолт .	15
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ.....	21
Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо, нас хүйсийн бүтэц.....	23
Монгол Улсын иргэдийн амьдарч буй гадаад улс, орон	29
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ31	
Үндэс, угсаа.....	33
Боловсролын байдал	33
Гэр булийн байдал.....	35
ДӨРӨВҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ГАДААДАД ЯВСАН ЗОРИЛГО, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, АЖИЛ ЭРХЛЭЛТ.....	37
Монгол Улсын иргэдийн гадаад явсан зорилго.....	39
Гадаадад оршин суугаа хугацаа	42
Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн ажил эрхлэлт	43
ТАВДУГААР БҮЛЭГ. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН МОНГОЛ ДАХЬ ГЭР БУЛИЙН ГИШҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ	49
Гадаадад оршин суугаа ам булийн гишүүнтэй өрхийн төлөв байдал	51
Гадаадад амьдарч байгаа хүнтэй өрхийн гишүүдийн эдийн засгийн идэвх	55
Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж	59
ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ХУРААНГУЙ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	63
Гадаадад оршин суугаа иргэдийн нийгэм эдийн засгийн талаарх хураангуй	64
Гадаад оронд амьран суугаа Монгол Улсын иргэдэд учирдаг хүндэрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга зам, санал, зөвлөмж.	66
ХАВСРАЛТ	69
ТООЛЛОГЫН АСУУЛГЫН ХУУДАС	77



СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Нацагдоржийн Тунгалаг

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн тэнхимиийн эрхлэгч,
Эдийн засгийн ухааны доктор, профессор

Дагвадоржийн Сайнбаяр

Хүний нөөц, нийгмийн хамгааллын сан ТББ-ын судлаач
Хуульч

Бямбаагийн Бямбасүрэн

Хүний нөөц, нийгмийн хамгааллын сан ТББ-ын судлаач

ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Цэнджавын Бадрах

Эдийн засагч
ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

Самдангийн Цэдэндамбаа

Эрх зүйч, Хуульч
Хууль зүйн ухааны доктор, профессор

Жигжидсүрэнгийн Ядамсүрэн

Санхүү-Эдийн засагч
Эдийн засгийн ухааны доктор, профессор

ГУРАВ.ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Чимэддамбын Лхагвадулам

Эдийн засагч-Эконометрикч, Бизнесийн удирдлагын магистр
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, хүйсийн харьцаа, насын бүлэг, хүйсээр, хувиар, 2010....	24
Хүснэгт 2.2.	Гадаадад суугаа иргэд, байнга оршин сууж байсан аймаг, нийслэлээр, 2010.....	26
Хүснэгт 2.3.	Гадаадад оршин суугаа иргэд, байнга оршин сууж байсан аймаг, нийслэл, оршин суугаа улс, хувиар, 2010 он	27
Хүснэгт 2.4.	Гадаадад оршин суугаа иргэд, байнга оршин сууж байсан бус, оршин суугаа бус нутаг, хувиар, 2010 он.....	29
Хүснэгт 2.5.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа улс, хүйс, хувиар, 2010 он	30
Хүснэгт 3.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн боловсролын төвшин, насын бүлэг, хувиар, 2010.....	35
Хүснэгт 3.2.	15, Түүнээс дээш насын гадаадад оршин суугаа иргэдийн гэр бүлийн байдал, насын бүлэг, хувиар, 2010.....	36
Хүснэгт 4.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн явсан зорилго, насын бүлэг, хувиар, 2010 он	40
Хүснэгт 4.2.	Гадаадад оршин суугаа иргэдийн явсан зорилго, оршин суугаа улс, хувиар, 2010.....	41
Хүснэгт 4.3.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа хугацаа, улсаар, 2010 он	43
Хүснэгт 4.4.	Гадаадад оршин суугаа иргэдийн ажил эрхлэлтийн байдал, явсан зорилго, хувиар, 2010 он....	44
Хүснэгт 4.5.	Гадаадад оршин суугаа иргэдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хувиар, 2010 он.....	46
Хүснэгт 5.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, өрхийн ам бүлийн тоогоор, 2010	51
Хүснэгт 5.2.	Өрхийн тоо, өрхийн ам бүлийн тоогоор, 2010	52
Хүснэгт 5.3.	Гадаадад оршин суугаа өрхийн гишүүдийн бүтэц, монгол дахь өрхийн тэргүүлэгчийн хамаарал, хувиар, 2010.....	53
Хүснэгт 5.4.	Гадаадад суугаа өрхийн гишүүдийн тоо, гадаад явсан зорилго, ам бүлийн тоогоор, хувиар, 2010.....	54
Хүснэгт 5.5.	15, Түүнээс дээш насын хүн амын эдийн засгийн идэвх, 2010.....	56
Хүснэгт 5.6.	Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2010	59
Хүснэгт 6.1.	Тэтгэврийн даатгалд даатгуулсан даатгуулагчдын тоо	66



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, 2010 он	23
Зураг 2.2.	Хүн амын насны бүтэц, хувиар, 2010 он	23
Зураг 2.3.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он	25
Зураг 2.4.	Гадаадад оршин суугааиргэдийн хүйсийн харьцаа, зарим улсаар, 2010 он.....	25
Зураг 2.5.	Гадаадад оршин суугаа иргэд, оршин суугаа зарим улс, хувиар, 2010 он	29
Зураг 2.6.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа зарим улс, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он.....	30
Зураг 3.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн үндэс, угсаа, 2010 он	33
Зураг 3.2.	Гадаадад оршин суугаа 10, түүнээс дээш насны иргэдийн боловсролын байдал, 2010 он	33
Зураг 3.3.	Гадаадад оршин суугаа 10, түүнээс дээш насны иргэдийн боловсролын байдал, хүйс, хувиар, 2010 он.....	34
Зураг 3.4.	15, Түүнээс дээш насны гадаадад оршин суугаа иргэдийн гэр бүлийн байдал, 2010 он	35
Зураг 3.5.	15, Түүнээс дээш насны гадаадад оршин суугаа иргэдийн гэр бүлийн байдал, хүйсээр, хувиар, 2010 он	36
Зураг 4.1.	Гадаадад оршин суугаа иргэдийн явсан зорилго, 2010 он	39
Зураг 4.2.	Гадаадад оршин суугаа иргэд, оршин суугаа хугацаагаар, хувиар, 2010 он	42
Зураг 4.3.	Гадаадад оршин суугаа иргэдийн ажил эрхлэлтийн байдал, хүйс, хувиар, 2010 он.....	44
Зураг 4.4.	15, Түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн гадаад явсан зорилго, 2010 он.....	45
Зураг 4.5.	Гадаадад оршин суугаа иргэдийн эдийн засгийн үйл ажиллагаа, зарим улс, хувиар, 2010 он	47
Зураг 5.1.	Гадаадад суугаа хүнтэй өрхийн бүтэц, гадаадад буй хүний тоогоор, хувиар, 2010	52
Зураг 5.2.	Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн ам бүлийн бүтэц, хувиар, 2010.....	53
Зураг 5.3.	Гадаадад суугаа хүний монгол дахь өрхийн ам бүлийн бүтэц, хувиар, 2010.....	54
Зураг 5.4.	Хүн амын насны бүтэц, хувиар, 2010	55
Зураг 5.5.	15, Түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам, гадаадад оршин суугаа гишүүнтэй эсэх, хувиар, 2010 он	56
Зураг 5.6.	15, Түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаан, хувиар, 2010 он	57
Зураг 5.7.	Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн 15, түүнээс дээш насны ажил эрхлэхгүй байгаа хүмүүс, шалтгаан, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	58
Зураг 5.8.	Гадаадад оршин суугаа гишүүнтэй болон гишүүнгүй өрх, өрхийн сууцны төрөл, хувиар, 2010 он.....	59
Зураг 5.9.	Гадаадад оршин суугаа гишүүнтэй болон гишүүнгүй өрх, байшингийн төрөл, хувиар, 2010	60

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он	70
Хүснэгт 2.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа улс, хүйсээр, 2010 он.....	70
Хүснэгт 3.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, насны бүлэг, оршин суугаа улсаар, 2010 он	71
Хүснэгт 4.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин сууж байсан аймаг, нийслэл, оршин сууугаа улсаар, 2010 он.....	72
Хүснэгт 5.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, насны бүлэг, явсан зорилгоор, 2010 он.....	73
Хүснэгт 6.	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо, оршин суугаа улс, явсан зорилгоор, 2010 он	74
Хүснэгт 7.	Гадаадад оршин суугаа 15, түүнээс дээш насны иргэдийн тоо, насны бүлэг, гэрлэлтийн байдал, хувиар, 2010 он.....	75



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГХЯ	Гадаад харилцааны яам
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ЭСЯ	Элчин сайдын яам

Австри	Бүгд Найрамдах Австри Улс
Англи	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
Болгар	Бүгд Найрамдах Болгар Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Герман	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
Ирланд	Бүгд Найрамдах Ирланд Улс
Итали	Бүгд Найрамдах Итали Улс
Казахстан	Бүгд Найрамдах Казахстан Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
Польш	Бүгд Найрамдах Польш Улс
Турк	Бүгд Найрамдах Турк Улс
Унгар	Бүгд Найрамдах Унгар Улс
Франц	Бүгд Найрамдах Франц Улс
Швейцар	Швейцарын Холбооны Улс
Энэтхэг	Бүгд Найрамдах Энэтхэг Улс

ӨМНӨХ ҮГ



Монгол Улс 2010 онд хүн амаа 10 дахь удаагаа амжилттай тоолж, үр дүнг тархаах, олон нийтэд хүргэх ажил хийж байна. Тооллогын нэгдсэн дунгийн номыг хэвлэн гаргаж нийтийн хүртээл болгосон ба 13 төрлийн сэдэвчилсэн судалгааг эрдэмтэн, судлаачид, статистикчдийн мэдлэг чадварыг дайчлан хийж байна. Үүний нэг нь "Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд" сэдэвт судалгаа юм. Энэхүү сэдэвчилсэн судалгааг 2010 оны Хүн ам, орон сууцны тоологоор гадаадад оршин суугаа иргэдээ анх удаа интернет, орчин үеийн технологийн дэвшилтэд шийдэл ашиглан тоолсонтой уялдаж анх удаа хийж байна.

Хүн ам орон сууцны тооллого явуулах товын дагуу интернет ашиглан гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн тоо, нас, хүйсийн бүтэц, нийгэм, эдийн засгийн байдлын талаар мэдээлэл авч нэгтгэн дүгнэсэн нь цаашид төр засгаас гадаад шилжих хөдөлгөөний талаар баримтлах бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах үндэслэл болох чухал мэдээллийг бүрдүүлж өгөв.

"Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд" сэдэвчилсэн судалгаа нь 6 бүлгээс бүрдجээ. Эхний бүлэгт 6 сараас дээш хугацаагаар гадаадад оршин суугаа иргэдийг тоолох үйл ажиллагааны зохион байгуулалт, онцлогийг тусгасан бол хоёрдугаар бүлэгт гадаадад оршин суугаа иргэдийн тоо, нас, хүйсийн бүтцийн холбогдолтой мэдээллийг оруулснаас гадна оршин сууж байсан болон одоо амьдарч байгаа улс, орны хамаарлыг харуулсан мэдээлэл багтжээ. Гуравдугаар бүлэгт гадаадад оршин суугаа иргэдийн боловсролын төвшин, гэр бүлийн байдал, үндэс угсаа зэрэг хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтийг оруулж дараагийн бүлэгт иргэдийн гадаадад зорчсон шалтгаан, амьдарч буй хугацаа, хөдөлмөр эрхлэлт, ажиллаж байгаа эдийн засгийн салбарын бүтэц, бүрэлдэхүүнийг харуулсан нь гадаадад ажиллах хүч гаргах, тэдний нийгмийн хамгааллын талаар бодлого, хөтөлбөр боловсруулахад үндэслэх үнэ цэнэтэй мэдээлэл болсон гэж үзэж байна. Гадаадад оршин суугаа иргэдийн Монгол дахь ар гэрийн гишүүдийн эдийн засгийн идэвх, орон сууцны нөхцөл байдлыг дараагийн бүлэгт тусгасан нь гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн явсан зорилго, зорилтын үр дүнг тодорхойлох боломжийг олгож байна. Судалгааны төгсгөлд гадаадад суугаа иргэдийн нийгэм эдийн засгийн байдлын талаар хураангуйлан оруулсны гадна тэдэнд учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга замын талаар санал, хүсэлт, зөвлөмж тусгажээ.

УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА,

С. МЭНДСАЙХАН

НЭГЛҮГЭЭР БУЛЭГ

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙГ
ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ОНЦЛОГ

Монгол Улсын эдийн засаг өсөн тэлж, нэр хүнд олон улсын тавцанд дээшилж, гадаад харилцаа сайжирч, ардчилал баталгаажихын хэрээр монголчууд бусад оронд зорчих, гадаадад ажиллах, сурч боловсрох боломж нэмэгдэж олон мянган охид, хөвгүүд гадаадад түр болон удаан хугацаагаар амьдрах болоо. Түүнчлэн үндсэн хуулиар олгогдсон “**Монгол Улсын иргэн гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрх**”¹- ийн дагуу гадаадад зорчих, амьдрал суух иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь түүнийг зохицуулах арга механизмыг боловсронгуй болгох, шинэлэг арга барилаар хандах шаардлага тавигдаж байгааг харуулж байна. Энэ хэрэгцээ шаардлагын үүднээс гадаадад оршин суугаа иргэдээ тоолж, сэдэвчилсэн судалгаа хийж байгаа нь энэ удаагийн тооллогын онцлог юм.

Манай орны иргэд сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг шалтгааны улмаас гадаадын олон улс оронд зорчих нь улам нэмэгдэж байна. Иймээс хуулийн дагуу хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийхээ талаар бодитой тоо мэдээллийг бэлтгэх ажлыг зохион байгуулав. Энэ нь төр засгаас гадаадад ажиллаж, сурч байгаа иргэнийхээ талаар баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулахад үндсэн мэдээлэл болох учиртай.

Монгол Улс Хүн ам, орон сууцны 10 дахь удаагийн тооллогыг 2010 оны 11 дүгээр сарын 11-17-ны хооронд амжилттай зохион байгуулан явуулж, үр дүнг боловсруулан тархаах ажил хийж байна.

Энэ тооллого хэд хэдэн онцлогтой. Эдгээрийн нэг нь гадаадад ажиллаж, суралцаж байгаа болон хувийн хэргээр оршин суугаа Монгол Улсын иргэнийг хүн ам, орон сууцны тооллогод хамруулна² гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж, гадаадад оршин суугаа иргэдээ анх удаа интернэтээр тоолсон явдал юм. Түүнчлэн тооллогын үр дүнг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, судалгааны байгууллага, судлаачид болон олон нийтэд орчин үеийн газар зүйн мэдээллийн системийг ашиглан хамгийн энгийн, ойлгомжтой хэлбэрээр тархаах боломжийг бүрдүүлсэн анхны тооллого боллоо.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу “Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад түр болон байнга оршин суугаа Монгол Улсын иргэдийн тооллогыг зохион байгуулж явуулах”³ үүрэгтэй. Тооллого явуулахад Үндэсний статистикийн хороо нэгдсэн аргачлал, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэгтэйн дагуу гадаадад оршин суугаа иргэдийг тоолох удирдамж, заавар, програм хангамж боловсруулан ажилласан.

Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн талаар мэдээлэл цуглуулах ажлыг гадаадад оршин суугаа иргэний Монгол дахь ар гэрийнхнээс асуух /Маягт ХАОСТ-1/, иргэн өөрөө интернетээр эсвэл гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт очиж тоолуулах /Маягт ХАОСТ-1.2/ замаар зохион байгуулсан.

“Танай өрхийн ам бүлийн гишүүдээс гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа хүн бий юу?” гэх асуултыг Монгол Улсын нутаг дэвсгэрт тоолуулсан өрх бүрээс асуусны дунд гадаадад байгаа иргэдийнхээ талаар товч мэдээллийг бүрдүүлэх, тэдний Монгол дахь ар гэрийн төлөв байдлыг бусад өрхтэй харьцуулан судлах боломж нээгдсэн юм.

1 Монгол Улсын үндсэн хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл. I боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 5

2 Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай Монгол Улсын хууль, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 32

3 Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай Монгол Улсын хууль, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 37



Харин иргэд өөрсдөө интернэтэд холбогдож тоолуулах боломжийг нээх үүднээс тооллогын цахим хуудсанд интернэт тооллогын холбоос нээж ажиллуулсан. Вэбэд суурилсан програм хангамж боловсруулах, вэб үйлчилгээ бүрдүүлэх, мэдээллийг нууцлахтай холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний дата төв, Тагнуулын ерөнхий газар зэрэг байгууллагын чиг үүргийн эрх зүйн зохицуулалтад нийцсэн зохион байгуулалтын ажлууд хийсэн юм. Интернэтээр мэдээлэл цуглуулсан анхны тооллого тул мэргэжлийн болон зохион байгуулалтын туршлага хомс байсан, түүнчлэн, төрийн байгууллагын хооронд мэдээлэл солилцох, мэдээллийг нууцлах, аюулгүй байдлыг хангахад эрх зүйн орчны зарим хүндрэл гарч байв.

Иргэдийг интернэтээр бүртгэх, зөвшөөрөл олгох, тооллогын асуулгыг интернэтээр нөхүүлэх, хариу мэдээлэл өгөх програм хангамжийг YСХ боловсруулж, Үндэсний дата төв вэб үйлчилгээгээр хангах ажлыг хэрэгжүүлсэн.

Гадаадад оршин суугаа иргэдийн ажиллаж, амьдарч буй орчны технологийн нөхцөл адилгүй, зарим хүнд зохих төвшний технологийн мэдлэг дутагдаж байсан тул тооллогын асуулгыг хэвлэх нөхүүлээд YСХ-нд ирүүлэх арга хэмжээг Монгол Улсаас тухайн улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд зохион байгуулсан юм.

УХУУЛГА, СУРТАЛЧИЛГАА, СУРГАЛТ

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн дагуу гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийг тоолох бэлтгэл ажлыг хангаж, чанартай зохион байгуулах зорилгоор “Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газарт Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах удирдамж”-ийг Үндэсний статистикийн хорооны дарга, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалаар баталж, мөрдөж ажилласан. Энэхүү удирдамжийн үндсэн зорилго нь Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тооллогын комисс, түр товчооны ажилтнуудад сургалт зохион байгуулж, мэдлэг олгох, чадвар эзэмшүүлэх, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын талаар гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдэд ухуулан сурталчлах, тэдэнтэй уулзах, хамтарч ажиллах, тэднийг тоолоход тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хамтарч шийдвэрлэхэд оршиж байв.

Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тооллогын ажилтны сургалт, сурталчилгааны ажлыг Гадаад харилцааны яамны тооллогын комисс, түр товчоотой хамтран Ази тив, зүүн Европ, баруун Европ, Америкийн Нэгдсэн Улс (АНУ) гэсэн чиглэлд зохион байгуулж явуулсан. Дээрх чиглэлийн хүрээнд Сөүл, Токио, Бээжин, Бангкок, Москва, Эрхүү, Варшав, Прага, Софи, Будапешт, Берлин, Лондон, Парис, Нью-Йорк, Чикаго, Денвер, Сан-Франциско зэрэг нийт 17 хотод зохион байгуулсан сургалтад дипломат төлөөлөгчийн газрын тооллогын түр товчооны ажилтнуудаас гадна монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага, холбоод, банк, санхүү, нийгмийн даатгал, ажиллах хүч зуучлах байгууллага, монголчуудад мэдээлэл хүргэдэг цахим хуудас, радио, сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага, хувь хүмүүс өргөнөөр оролцсон.

Тооллогын цахим хуудас “www.toollogo2010.mn”-ыг 2010 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс ажиллуулж эхэлсэн нь тооллоготой холбоотой бүхий л мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчилгааны ажлын гол хэлбэр байв. ГХЯ хилийн чанадад амьдран суугаа иргэдэд мэдээлэл хүргэхэд голлох үүрэгтэй ажилласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

ТООЛЛОГЫН АСУУЛГА БОЛОВСРУУЛАЛТ, ТООЛОХ ҮЕ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын зорилго, хамрах хүрээг харгалзаж, тооллогын асуулгыг боловсруулахдаа НҮБ-аас бэлтгэж, гишүүн орнууддаа зөвлөмж болгосон “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийн дагуу хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үзүүлэлтийг тооллогын асуулгад тусгасны зэрэгцээ интернэтээр тоолох асуултыг тусад нь боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, заавар батлах тухай” 2010 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/127 дугаар тушаалаар “Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийг тоолох интернэт тооллогын асуулга (Маягт ХАОСТ-1.2), зааврыг баталж ажилласан.

Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийг интернетээр тоолох асуулга (Маягт ХАОСТ-1.2) нь тооллогын зорилгод нийцүүлсэн хаягийн хэсгээс гадна тухайн хүний өрхийн тэргүүлэгчийн хамаарал, хүйс, нас, үндэс, угсаа, гэр булийн байдал, эзэмшсэн боловсрол, ажил мэргэжил, гадаад явсан зорилго, гадаадад оршин суугаа хугацаа, төрсөн газар, гадаад явхаасаа өмнө амьдарч байсан аймаг, нийслэл зэрэг нийт 12 асуултаас бүрдсэн. Харин энд тэдний Монгол дахь гэр бүл, тэдгээрийн орон сууцтай холбоотой ямар нэг мэдээлэл тусгагдаагүй юм.

Интернетээр тоолох ажиллагааг 2010 оны 11 дүгээр сарын 1-нээс эхэлж, 11 дүгээр сарын 21-нийг дуустал явуулсан. Хүн ам, орон сууцны тооллогод хүн нэг бүр оролцохын чухлын талаар ухуулга сурталчилгааг эрчимтэй явуулахын зэрэгцээ төр засгаас явуулж байгаа арга хэмжээ ялангуяа, эх орны хишиг, хувь хүртээхэд тооллого, бүртгэлд хамрагдаж, иргэн хүний үүргээ биелүүлсэн байх тухай иргэдэд таниулж байсан нь нөлөөлж, гадаадад байгаа өрхийн гишүүдээ тооллогод хамруулах талаар эх орондоо буй өрхийн гишүүдийн идэвх өндөр байсан нь тооллого явуулах хугацаанд илүүтэй мэдрэгдэж байв.

Тооллогын мэдээлэл боловсруулалтын үед дипломат төлөөлөгчийн газруудаас ирүүлсэн ХАОСТ-1.2 асуулгыг шивж, ХАОСТ-1 маягтаар Монголд байгаа ар гэрийхнээс нь асууж тоолсон болон интернетээр тоолуулсан хүмүүсийн давхардлыг арилгаж, тооллогын дүнг баталгаажуулсан юм.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙГ ТООЛОХОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн амаа тоолох нэг онцлог бол тооллогын товын талаарх асуудал байдаг. Энэ нь хүн төрөх, нас барах, засаг захирагааны нэг нэгжээс нөгөөд эсвэл гадаадад шилжин явах, ирэх зэргээр байнгын хөдөлгөөнд орж байдагтай холбоотойгоор улс орны хүн амын тоог тодорхой хугацаагаар тасалбар болгодог олон улсын жишиг ойлголт юм. Тооллогын товыг 2010 оны 11 дүгээр сарын 10-наас 11-нд шилжих шөнийн 00 цагаар тогтоосон.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙГ ТООЛОХОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ХҮН АМЫН БАЙРШИЛ, НУТАГ		
1.	Төрсөн газар	Тоолуулагч Монгол Улсад төрсөн бол аймаг, нийслэлийн нэрийг, хэрвээ гадаад улсад төрсөн бол тухайн улсын нэрийг, жагсаалтад байхгүй бол бусад гэдгийг сонгоно.



2.	Монголд байнга сууж байсан аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, код	Гадаад явахаасаа өмнө Монгол Улсад байнга оршин суудаг (сууж байсан) аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, харгалзах код
3.	Гадаадад оршин суугаа хугацаа	Гадаадад оршин суугаа хугацааг бүтэн жилээр нөхнө.

БОЛОВСРОЛ

4.	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2010 онд ЕБС-ын 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
5.	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
6.	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл) 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал) 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
7.	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10-р ангийг (2006 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
8	Техникийн болон мэргэжлийн боловсрол	MCYT (хуучнаар ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
9.	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
10.	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ.

ГЭР БУЛИЙН БАЙДАЛ

11.	Огт гэр бүл болоогүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
12.	Батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр булийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
13.	Батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр булийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн

14. Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацааг харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
15. Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ.
16. Бэлбэсэн	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг Бэлбэсэн гэж үзнэ.

АЖИЛ ЭРХЛЭЛТ

17. Ажил эрхэлдэг хүн	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн хүн
18. Ажилгүй хүн	Хөдөлмөр хalamж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсвэл бүртгүүлээгүй, товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн

ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

19. Хөдөө аж ахуй, оин аж ахуй, загас барилт, ан агнуур	Мал, амьтны болон таримал, байгалийн ургамлын нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа орно. Үүнд: газар тариалан эрхлэх, мал, амьтныг өсгөх, үржүүлэх, түүний ашиг шимиг авах; загас барих; ан агнуур; ойжуулалт, мод бэлтгэл; фермерийн аж ахуйн үйл ажиллагаа зэрэг хамаарна.
20. Үул уурхай, олборлолт	Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох үул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
21. Боловсруулах үйлдвэрлэл	Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эдийг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүнд нь хөдөө аж ахуй, оин аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд, бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.
22. Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа орно. Түүнчлэн нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эх үүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах, түгээх ажиллагаа багтана.



23. Ус хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах явцтай холбоотой үйл ажиллагаа багтана. Хог хаягдал, бохир ус боловсруулах үйл ажиллагааны үр дүнд ариутгасан эсвэл шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно. Усан хангамжийн үйл ажиллагаа нэгтгэгдэн энэ салбарт орно. Ус хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байдаг ба аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно.
24. Барилга	Барилга угсралт болон инженерийн байгууламж, байшин, барилгыг угсрах болон мэргэжсэн барилгын үйл ажиллагаа энэ салбарт багтана. Энд шинэ ажил, барилга засвар, нэмэлт болон жижиг засвар, угсармал барилга, барилгын талбай, түр зуурын чанартай барилга угсрах үйл ажиллагаа орно.
25. Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ машин, мотоциклийн засвар, үйлчилгээ хамаарна.
26. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа ба зорчигч тээвэрлэлт, агуулах, ачаа, тээшийн үйлчилгээ, автомашины зогсоол, гарааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
27. Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Түр зуурын зочин, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт тусгагдаж байгаа нэмэгдэл үйлчилгээний хэмжээ, төрөл нь нилээд их байна.
28. Мэдээлэл, холбоо	Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, тухайлбал, холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбоотой бусад үйл ажиллагаа орно.
29. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Даатгалын үйл ажиллагаа, давхар даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, мөн санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагааг оруулан санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагааг энэ салбарт орно. Холдинг компани, траст, сан болон санхүүгийн бусад үйл ажиллагаа зэрэг холдинг хөрөнгийн үйл ажиллагаа энэ салбарт багтана.


30. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ олгогчид, агентууд, брокеруудын үл хөдлөх хөрөнгө арилжаалах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үл хөдлөх хөрөнгийн бусад үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэж эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн энд эзэмшигчийн эсвэл лизингийн баригдаж байгаа барилга болон барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгийн менежерийн үйл ажиллагаа багтана.
31. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа энэ салбарт орно. Эдгээр үйл ажиллагаа нь өндөр түвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар олгох зэрэг байна.
32. Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Ерөнхий бизнесийн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна.
33. Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Төрийн удирдлагаар хэрэгждэг үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол ба тэдгээрийн зохицуулалт, тэдгээр дээр сууринсан үйл ажиллагаануудын удирдлага, хууль тогтоо үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачлалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа ба засгийн газрын хөтөлбөрүүдийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
34. Боловсрол	Энэ салбарт бүх шатны, бүх мэргэжлийн боловсролыг өдөр, орой, эгнээ хэлбэрээр анги, танхим, радио, телевиз болон бусад мэдээллийн хэрэгсэл, зайн сургалтаар дамжуулан олгосон боловсролын үйл ажиллагаа орно. Төрөл бүрийн сургалтын байгууллагын албан болон албан бус сургалт багтана. Түүнчлэн насанд хүрэгчдийн боловсрол, бичиг үсэг тайлгадалтын хөтөлбөр зэрэг орно. Мөн бүх насны цэргийн сургууль, академи, хориыхын сургууль хамрагдана.
35. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Энэ салбарт эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа орно. Үйл ажиллагаанд нь эмнэлгийн анагаахын мэргэжилтнүүдэд эмнэлэг болон бусад сургалтын сургагдсан эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанаас эхлэн хүн амыг асрах үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ болон заавал мэргэжлийн эмнэлгийн ажилтан бус нийгмийн ажилтны үйл ажиллагаа багтана.
36. Урлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ дэд салбарт өргөн цар хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам багтахын зэрэгцээ амьд үзүүлбэр, музейн үйлчилгээ, мөрийтэй спорт, амралт зугааллыг үйл ажиллагаа хамрагдана.



37. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт байгууллагуудын гишүүнчлэлтэй холбоотой үйл ажиллагаа, компьютерын болон хувь хүн, өрхийн хэрэглээний барааны засвар үйлчилгээ орох бөгөөд өмнөх, бүлэг, ангид ороогүй хувь хүнтэй холбоотой төрөл бүрийн бусад үйлчилгээний үйл ажиллагаа орно.
38. Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; Өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	Гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угаач, цэцэрлэгч, манаач, малчин, ногоочин, байнгын харгалзагч, жолооч, хаалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгээр хийх үйл ажиллагаа орно. Энд зөвхөн өөрийн хэрэглээ, амь зуулгандаа зориулан, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй хэд хэдэн төрлийн бараа болон үйлчилгээ явуулдаг өрх хамрагдана.
39. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Энэ ангид Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн төрөлжсөн байгууллагууд, бус нутгийн төлөөлөгчид, Олон улсын валотын сан, Дэлхийн банк, Дэлхийн гаалийн байгууллага, Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Нефть экспортлогч орнуудын байгууллага, Европын холбоо, Европын худалдааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагын үйл ажиллагаа орно. Тухайн улс оронд байрлаж буй дипломат болон консулын төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь аль улсыг төлөөлж байгаагаас үл хамааран энэ ангид мөн багтана.

ХОЁРЛУГААР БҮЛЭГ

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН
ТӨӨ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ



ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 2,754,685 хүн тоологдсны 2,647,545 нь Монгол Улсын нутаг дэвсгэрт, 107,140 нь гадаадад тоологдов. Монгол Улсын нийт хүн амын 4 хувь гадаадад оршин сууж байна.


Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 63,870 иргэнийг Монголд байгаа гэр бүлийн гишүүд нь тоолуулсан (Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, Маягт ХАОСТ-1) бол 44,270 иргэн өөрөө интернэтэд хандаж, эсвэл гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт очиж тоолуулжээ (Хүн ам, орон сууцны 2010 оны улсын интернэт тооллогын асуулга, Маягт ХАОСТ-1.2).

ЗУРАГ 2.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, 2010 ОН



Насны бүлгээр авч үзвэл гадаадад оршин суугаа иргэдийн 82.5 хувийг ид ажиллах, сурч боловсрох 15-44 насныхан эзэлж байгаа нь улсын хэмжээний мөн насны хүн амын эзлэх хувиас 28.4 пунктээр өндөр байна. Харин 0-14 насны хүүхэд багачууд 10.6, 45-с дээш насныхан 6.9 хувийг эзэлж байна (Зураг 2.1).

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад оршин суугаа хүн амын 8.6 хувь буюу 9.2 мянга нь 15-19 настай, 15.8 хувь буюу 16.9 мянга нь 30-34 настай, 12.4 хувь буюу 13.3 мянга нь 35-39 настай, 7.4 хувь буюу 7.9 мянга нь 40-44 настай хүн байна. Монгол Улсаас гадаадад оршин суугаа 10 хүний 4 нь 20-29 насны залуучууд байна.




**ХҮСНЭГТ 2.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА,
НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010**

Насны бүлэг	Гадаадад оршин суугаа иргэд				МУ-ын нийт хүн амын хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	
БҮГД	107 140	46.6	53.4	87.4	98.1
0-4	4 598	2.2	2.1	100.9	103.2
5-9	3 171	1.5	1.5	101.2	103.8
10-14	3 535	1.7	1.6	100.4	102.8
15-19	9 176	4.1	4.4	92.9	102.4
20-24	20 400	9.5	9.6	99.3	101.7
25-29	20 739	9.5	9.9	96.1	100.4
30-34	16 855	7.0	8.7	80.2	99.6
35-39	13 343	5.4	7.0	76.8	97.7
40-44	7 930	3.2	4.2	74.3	95.9
45-49	4 168	1.5	2.4	64.1	94.4
50-54	1 883	0.7	1.1	65.0	90.1
55-59	709	0.3	0.4	61.1	86.2
60-64	304	0.1	0.2	62.6	80.7
65-69	162	0.1	0.1	50.0	82.2
70+	167	0.0	0.1	40.3	66.8

Монгол Улсын нийт хүн амын 50.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол гадаадад оршин суугаа иргэдийн 53.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь 2.9 пунктээр илүү юм. Гадаадад тоологдсон иргэдийн 50.0 мянга нь эрэгтэй, 57.2 мянга нь эмэгтэйчүүд байсан нь хүйсийн харьцаа 87.4 буюу 100 эмэгтэйд 87.4 эрэгтэй ногдож байгааг тодорхойлж өглөө. Гадаадад оршин суугаа 0-14 насныхны хүйсийн харьцаа бараг тэнцүү, эрэгтэйчүүд арай олон байгаа нь төрөх үеийн хүйсийн харьцаанаас шалтгаалж байна. Гадаадад оршин суугчдын 20-иод хувийг эзэлдэг 20-24 насныхны хүйсийн харьцаа 99.3 байгаа нь сайн үзүүлэлт, 25-29 насныхны хувьд ч хүйсийн харьцаа 96.1 хувь байгаа нь улсын дундажтай ойролцоо, харьцангуй боломжийн үзүүлэлт гэж үзэж болно.


Хүйсийн харьцаа нас ахих тусам буурах нь жам ёсны хэрэг боловч, гадаадад оршин суугаа 30-54 насны иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгааг Зураг 2.3-с тодорхой харж болно.

ЗУРАГ 2.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010
ОН



Гадаадад оршин суугаа иргэдийн хүйсийн харьцаа улс бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал БНСҮ, ОХҮ-д ажиллаж, сурч, амьдарч байгаа иргэдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа бол Япон, АНУ, БНЧҮ, БНХАУ-д ажиллаж, сурч, амьдарч байгаа иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 2.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ЗАРИМ
УЛСААР, 2010 ОН





ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор гадаадад оршин суугаа иргэдийн Монголд байнга амьдарч байсан аймаг, нийслэлийг тодруулж асуусан. Гадаадад оршин суугаа иргэдийн 80 хувь нь Улаанбаатараас, 7 хувь нь Дархан-Уул, Орхон аймгаас, 2.6 хувь нь Баян-Өлгий аймгаас гадаад руу явсан дүн гарч байна.

ХҮСНЭГТ 2.2. ГАДААДАД СУУГАА ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭР, 2010

Аймаг, нийслэл	Тоо	Дүнд эзлэх хувь	Аймаг, нийслэл	Тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	107 140	100.0			
Архангай	505	0.5	Сүхбаатар	243	0.2
Баян-Өлгий	2 824	2.6	Сэлэнгэ	1 780	1.7
Баянхонгор	395	0.4	Төв	1 330	1.2
Булган	588	0.6	Увс	422	0.4
Говь-Алтай	368	0.3	Ховд	617	0.6
Дорноговь	682	0.6	Хөвсгөл	593	0.6
Дорнод	679	0.6	Хэнтий	476	0.5
Дундговь	277	0.3	Дархан-Уул	3 978	3.7
Завхан	557	0.5	Улаанбаатар	85 758	80.0
Өвөрхангай	870	0.8	Орхон	3 581	3.3
Өмнөговь	459	0.4	Говьсүмбэр	158	0.2

Гадаадад оршин суугаа иргэдийн дийлэнх нь Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Төв, Сэлэнгэ аймаг зэрэг мэдээлэл, холбоо, зам харилцаа сайтай, хүн ам ихтэй суурин газраас явжээ. Эндээс дүгнэхэд гадаад орнуудад ажиллах, суралцах талаар үнэн зөв мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх болон гадаад оронд амьдрах, ажиллах, сурч боловсрох талаар манай улстай хийсэн гэрээ хэлцэл, тэнд амьдрах нөхцөл нь иргэдийн гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах нэг үндэс болж байна. Мөн иргэдийнхээ эх орондоо амьдарч байсан аймаг, бус нутгийг одоо амьдарч байгаа улс, оронтой нь харьцуулснаар гадаад шилжих хөдөлгөөний чиглэл, зорилго, хандлагыг тодорхойлох боломжийг бүрдүүлж байна.

Казахстанд амьдарч байгаа 2,523 хүний 80 гаруй хувь нь Баян-Өлгий аймгаас явжээ. Харин Өвөрхангай аймгаас гадаадад оршин суугаа 870 иргэний бараг 60 хувь нь БНСҮ-д ажиллаж, амьдарч байна. Улаанбаатар хотоос гадаадад суугаа нийт иргэдийн 27.5 хувь нь БНСҮ-д, 18.0 хувь нь АНҮ-д, 6.7 хувь нь БНХАҮ-д, 6.6 хувь нь БНЧҮ-д, 5.5 хувь нь Япон улсад амьдарч байна.

ХҮСНЭГТ 2.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ОРШИН СУУГАА УЛС, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	БНСУ	АНУ	БНЧУ	БНХАУ	Япон	ОХУ	Герман	Англи	Франц	Турк
БҮГД	100.0	27.6	15.9	6.8	6.8	5.0	4.7	3.6	3.5	2.7	2.5
Архангай	100.0	34.5	7.5	5.5	8.1	6.7	8.1	4.2	1.6	2.8	2.0
Баян-Өлгий	100.0	0.3	1.5	0.0	0.8	0.2	3.9	0.0	0.1	0.1	15.6
Баянхонгор	100.0	34.7	4.3	7.3	10.4	1.8	14.2	1.8	1.8	1.5	2.3
Булган	100.0	35.5	6.5	6.3	6.3	3.4	4.6	5.8	0.9	3.7	7.5
Говь-Алтай	100.0	53.3	8.2	6.0	5.7	3.0	5.2	1.9	1.1	1.9	0.8
Дорноговь	100.0	26.0	4.0	5.1	24.8	2.5	6.9	1.3	2.3	6.0	4.3
Дорнод	100.0	24.6	7.2	10.3	16.9	5.0	12.2	2.7	1.2	1.3	1.9
Дундговь	100.0	27.4	7.9	17.3	7.9	2.2	4.0	2.2	1.4	3.2	2.2
Завхан	100.0	50.1	7.5	3.9	5.6	3.4	7.5	1.3	1.6	0.4	2.2
Өвөрхангай	100.0	59.2	4.8	5.5	6.9	3.8	3.2	1.3	0.8	0.7	1.3
Өмнөговь	100.0	34.0	5.4	7.6	15.9	5.9	5.0	3.9	2.6	1.7	1.7
Сүхбаатар	100.0	26.3	6.6	9.1	23.9	2.1	5.3	3.7	2.5	2.9	2.5
Сэлэнгэ	100.0	29.3	8.5	7.6	7.2	2.5	13.3	4.3	2.3	5.4	4.2
Төв	100.0	34.4	8.5	8.6	7.1	5.1	3.9	1.7	3.3	2.4	3.1
Үвс	100.0	20.4	5.9	5.2	8.5	5.9	16.1	1.9	1.2	3.3	11.6
Ховд	100.0	32.9	4.5	1.1	11.5	5.8	5.3	1.1	2.3	0.3	5.2
Хөвсгөл	100.0	28.2	4.9	12.0	13.0	3.9	11.6	2.0	1.3	1.7	3.0
Хэнтий	100.0	30.9	3.8	13.9	8.8	3.4	8.4	1.9	1.9	1.5	2.3
Дархан-Уул	100.0	27.7	9.0	10.6	5.5	3.4	6.1	3.0	2.8	4.9	5.6
Улаанбаатар	100.0	27.5	18.0	6.6	6.6	5.5	3.9	3.9	3.8	2.7	1.6
Орхон	100.0	28.5	12.7	9.3	7.5	2.9	11.6	2.0	2.0	1.8	5.7
Говь-сүмбэр	100.0	32.9	5.7	10.1	5.7	4.4	7.6	1.3	4.4	5.7	6.3

ХҮСНЭГТ 2.3-ИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Аймаг, нийслэл	Казахстан	Унгар	Швейцари	Австри	Канад	Ирланд	Энэтхэг	Полыш	Австрали	Итали	Бусад
БҮГД	2.4	1.5	1.4	1.3	1.2	1.0	1.0	0.9	0.9	0.3	9.2
Архангай	0.0	2.8	0.4	1.4	0.4	1.4	4.2	0.2	1.0	0.0	7.3
Баян-Өлгий	72.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	5.1
Баянхонгор	0.5	1.5	0.0	0.5	0.5	0.5	5.6	0.5	0.0	0.0	10.4
Булган	0.7	1.0	1.9	0.2	0.3	2.2	2.4	0.3	0.2	0.2	10.2
Говь-Алтай	0.3	0.5	1.1	0.5	0.5	0.0	1.1	0.0	0.3	0.3	8.4
Дорнговь	0.4	0.0	3.1	1.3	0.0	0.1	3.2	0.7	0.3	0.1	7.5
Дорнод	0.0	0.7	0.1	0.3	0.3	1.0	2.2	0.0	0.3	0.6	11.0
Дундговь	0.0	5.8	0.4	2.5	0.0	0.7	5.4	0.0	0.0	0.0	9.4
Завхан	0.0	1.8	0.5	1.1	0.2	0.9	3.9	0.0	0.2	0.0	7.9
Өвөрхангай	0.0	0.9	0.9	0.3	0.1	0.0	3.6	0.3	0.2	0.2	5.9
Өмнөговь	0.2	0.9	1.5	1.3	0.0	0.9	1.7	0.0	0.7	0.0	8.9
Сүхбаатар	0.0	1.2	1.6	0.8	0.0	0.8	2.5	0.0	0.0	0.0	8.2
Сэлэнгэ	1.5	0.4	1.2	1.0	0.8	0.2	0.7	0.8	0.3	0.0	8.5
Төв	0.8	1.6	1.5	1.4	0.7	0.5	2.2	1.1	0.4	0.2	11.8
Увс	0.2	1.4	0.7	0.0	0.0	3.1	5.7	0.0	0.2	0.0	8.5
Ховд	17.5	0.0	1.1	0.5	0.8	0.5	0.8	0.6	0.3	0.0	7.6
Хөвсгөл	0.2	1.9	1.9	0.8	1.0	0.7	2.9	2.5	0.5	0.0	6.1
Хэнтий	1.3	0.0	2.7	0.6	0.2	0.8	0.6	0.4	1.5	0.0	15.1
Дархан-Уул	1.1	2.6	1.5	2.0	0.2	1.1	0.9	0.9	0.4	0.2	10.8
Улаанбаатар	0.3	1.6	1.5	1.3	1.4	1.1	0.9	1.0	1.0	0.3	9.3
Орхон	0.3	0.4	1.2	1.1	0.5	0.9	1.7	0.5	1.1	0.4	8.0
Говь-сүмбэр	1.3	1.9	1.9	0.0	0.6	0.0	0.6	0.6	0.0	0.0	8.9

Гадаадад оршин суугаа иргэдийн Монголд амьдарч байсан бүс нутаг одоо амьдарч байгаа бүс нутгийн хамаарлыг харвал Баруун бүсээс явагчдын 80 хувь нь БНСУ, Казакстанд амьдарч байхад Улаанбаатар хотоос явсан иргэдийн 18 хувь нь АНУ-д амьдарч байна.

Түүнчлэн Улаанбаатар хотоос гадаад явсан иргэдийн 45.0 хувь нь зүүн Ази, Номхон далайн бүс нутагт, 31.6 хувь нь Европд зорчсон бол зүүн бүсээс хамгийн их нь өмнөд Ази, Европ руу, баруун бүсээс зүүн Ази, Номхон далайн бүс нутагт явсан хүмүүс түгээмэл байна⁴.

⁴ Улсын Их хурлаас баталсан “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” 2003 он. Бүсүүд хамаарах аймаг, нийслэлийн нэр:

- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бусийн дагуул хотуудыг хамруулдаг.


**ХҮСНЭГТ 2.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БУС,
ОРШИН СУУГАА БУС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН**

Бус	Бүгд	Зүүн Ази, Номхон далайн бус нутаг	Европ	Америк	Өмнөд Ази	Африк
БҮГД	100.0	47.5	31.3	18.4	1.5	1.3
Улаанбаатар	100.0	45.0	31.6	20.8	1.3	1.3
Зүүн	100.0	52.5	35.6	7.9	2.3	1.7
Төв	100.0	49.5	37.1	10.0	1.9	1.5
Хангай	100.0	53.0	31.9	11.1	2.9	1.1
Баруун	100.0	79.8	13.2	4.6	1.5	0.9

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН АМЬДАРЧ БҮЙ ГАДААД УЛС, ОРОН

Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын 107,140 иргэн байгаагийн хамгийн олон буюу 27.6 хувь БНСУ, 15.9 хувь АНУ-д амьдарч байгаа бол эдгээрийн дараагаар БНЧУ, БНХАУ, Япон, ОХУ орж байна. Эдгээр улсад гадаадад оршин суугаа нийт иргэдийн 66.8 хувь нь ажиллаж, сурч, амьдарч байна.

**ЗУРАГ 2.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА ЗАРИМ УЛС, ХУВИАР,
2010 ОН**




ХҮСНЭГТ 2.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Оршин суугаа улс	Тоо	Дүнд эзлэх хувь	
		Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	107 140	46.6	53.4
БНСУ	29 534	56.1	43.9
АНУ	17 036	44.0	56.0
БНЧУ	7 274	41.5	58.5
БНХАУ	7 273	41.3	58.7
Япон	5 401	44.4	55.6
ОХУ	5 008	49.0	51.0
Герман	3 852	30.7	69.3
Англи	3 701	39.5	60.5
Франц	2 859	46.6	53.4
Турк	2 645	46.9	53.1
Казахстан	2 523	51.7	48.3
Унгар	1 615	34.8	65.2
Швейцари	1 509	30.2	69.8
Австри	1 346	35.1	64.9
Канад	1 259	46.3	53.7
Ирланд	1 124	43.2	56.8
Энэтхэг	1 116	68.4	31.6
Польш	999	43.8	56.2
Австрали	962	44.5	55.5
Итали	282	32.3	67.7
Бусад	9 822	42.9	57.1

Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн насны бүтэц оршин суугаа улс, орон бүрээр харилцан адилгүй болохыг Зураг 2.5-аас харж болно. Тухайлбал БНХАУ-д оршин суугаа иргэдийн дийлэнх нь 15-24 насныхан бол БНСУ-д оршин суугаа иргэдийн дийлэнх нь 25-34 насны залуучууд байна. Харин АНУ-д оршин суугаа иргэд харьцангуй олон насны булгийг төлөөлж байна.

ЗУРАГ 2.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА ЗАРИМ УЛС, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



ГУРАВЛУГААР БУЛЭГ


ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН
ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ



ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын нийт хүн амд Халхчууд 82.4 хувь, Казахууд 3.9 хувь, Буриадууд 1.7 хувийг тус тус эзэлж байгаа бол гадаадад оршин суугаа иргэдийн 87.7 хувийг Халхчууд, 1.5 хувийг Казахууд, 1.9 хувийг Буриадууд тус тус эзэлж байна. Монгол Улсын бүх угсаатны төлөөлөл гадаадад ажиллаж, амьдарч байна.


ЗУРАГ 3.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ҮНДЭС, УГСАА, 2010 ОН



БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ


Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 10, түүнээс дээш настай иргэдийн 38.4 хувь нь бүрэн дунд боловсролтой, 34.6 хувь нь бакалаврын боловсролтой байна. Бага боловсролтой, суурь боловсролтой хүмүүс тус бүрдээ 2.8-3.6 хувийг эзэлж байгаа бол доктор, магистрын зэрэгтэй хүмүүс тус бүр 1.3, 10.4 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН
БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ, 2010 ОН



Гадаадад оршин суугаа иргэдийн боловсролын төвшин дэх хүйсийн ялгаатай байдлыг Зураг 3.3-аас харж болно. Тухайлбал тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад ажиллаж, амьдарч байгаа 10, түүнээс дээш настай иргэдийн 1.3 хувь нь докторын зэрэгтэй, 10.4 хувь нь магистрийн зэрэгтэй хүмүүс байгаа талаар өмнө дурдсан. Улсын хэмжээнд 10, түүнээс дээш настай хүн амын 0.2 хувь нь доктор, 1.5 хувь нь магистрын зэрэгтэй байгаатай дээрх үзүүлэлтийг зэрэгцүүлэхэд манай улсын оюунлаг, сэхээтэн залуусын нэлээд хэсэг нь гадаадад ажиллаж, амьдарч байна гэж үзэж болохоор байна. Эх орондоо доктор, магистрын боловсрол эзэмшсэн чадварлаг залуус хилийн чанадыг зорьж, гадаадад ажиллаж, амьдарч байгаа тохиолдол нэлээд байдаг. Үүний зэрэгцээ гадаадад дээд боловсрол эзэмшиж, тэндээ ажиллаж, амьдарч байгаа хүмүүс ч олон бий. Энэ байдалд дүгнэлт хийж, чадварлаг боловсон хүчинээ эх орондоо татан авчрах талаар бодлого хэрэгжүүлэх цаг болсон байна.


**ХҮСНЭГТ 3.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, НАСНЫ
БҮЛЭГ, ХУВИАР, 2010**

Насны бүлэг	Бүгд	Доктор	Магистр	Дипломын болон бакалаврын	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
БҮГД	100.0	1.3	10.4	34.6	5.1	3.1	38.4	3.6	2.8	0.7
10-14	100.0	-	-	-	-	-	-	21.5	60.5	18.0
15-19	100.0	-	-	3.3	1.4	1.0	76.1	13.8	3.9	0.4
20-24	100.0	-	3.5	34.2	3.0	1.8	53.6	3.4	0.4	0.1
25-29	100.0	0.9	12.3	52.5	2.5	2.0	28.2	1.1	0.5	0.2
30-34	100.0	1.7	14.8	45.4	3.2	2.7	30.0	1.7	0.4	0.2
35-39	100.0	2.6	17.3	31.4	8.8	5.9	32.7	1.0	0.2	0.1
40-44	100.0	1.8	16.2	26.0	14.0	7.5	33.4	1.0	0.1	0.0
45-49	100.0	3.0	15.4	31.4	14.6	6.1	28.3	1.2	0.0	0.1
50-54	100.0	3.7	15.6	35.6	16.4	6.2	22.1	0.2	0.1	0.0
55-59	100.0	9.5	18.7	36.2	13.9	3.0	18.7	0.0	0.0	0.0
60-64	100.0	5.5	20.7	33.8	7.6	4.1	26.2	2.1	0.0	0.0
65-69	100.0	4.2	4.2	45.1	16.9	2.8	25.4	1.4	0.0	0.0
70+	100.0	7.6	4.5	34.8	10.6	6.1	21.2	7.6	6.1	1.5

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Гадаадад оршин суугаа 15, түүнээс дээш насны иргэдийн 47.7 хувь нь гэр бүлтэй (батлуулсан эсвэл батлуулаагүй), 46.6 хувь нь огт гэр бүл болоогүй хүмүүс байна.

ЗУРАГ 3.4. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, 2010 ОН



Улсын хэмжээнд 25-34 насны эрэгтэйчүүдийн 25.7, эмэгтэйчүүдийн 18.1 хувь огт гэр бүл болоогүй байна. Гэтэл гадаадад оршин суугаа мөн насны нийт иргэдийн 37.9 хувь огт гэр бүл болоогүй байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.


Түүнчлэн улсын хэмжээний 35-54 насны эрэгтэйчүүдийн 10.2, эмэгтэйчүүдийн 12.7 хувь гэр бүлээ цуцалсан эсвэл тусгаарласан байхад мөн насны гадаадад оршин суугаа иргэдийн 23.6 хувь нь гэр бүлээ цуцалсан эсвэл тусгаарласан байгаа нь гэр бүлийн нэг гишүүн удаан хугацаагаар гадаадад амьдрахад гэр бүл тогтвортгүй байдалд ордог гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

ХҮСНЭГТ 3.2. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2010

Насны бүлэг	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн
БҮГД	100.0	46.6	37.9	9.8	1.2	3.4	1.1
15-24	100.0	89.6	7.4	2.5	0.2	0.3	0.1
25-34	100.0	37.9	44.3	13.9	1.0	2.5	0.3
35-44	100.0	12.6	61.3	14.3	2.7	7.4	1.7
45-54	100.0	5.5	67.9	8.5	2.7	10.8	4.6
55-64	100.0	2.8	70.9	4.9	1.6	6.9	13.0
65+	100.0	2.2	59.4	0.0	1.4	0.7	36.2

Гадаадад удаан хугацаагаар оршин суугаа гэр бүлгүй (тусгаарласан, цуцалсан, бэлбэсэн) хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа нь анхаарал татаж байна. Гэр бүлгүй эмэгтэйчүүдийн дотор 45-аас дээш насныхан харьцангуй өндөр хувийн жин эзэлж байгаа нь тэд сурч, ажиллахаар гэхээсээ илүү үр хүүхдээ бараадан гадаадад амьдрах тохиолдол цөөнгүй байгааг харуулж байна.

ЗУРАГ 3.5. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010 ОН



ДОРӨВЛҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ГАДААД ЯВСАН ЗОРИЛГО,
ОРШИН СУУГАА ХУГАЦАА, АЖИЛ ЭРХЛЭЛТ




Монгол Улсын иргэд гадаад явсан зорилгыг насны бүлэг болон оршин суугаа улсаар нарийвчлан судалж, гадаадад оршин суугаа хугацаатай уялдуулан авч үзэв.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ГАДААД ЯВСАН ЗОРИЛГО

Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа иргэдийн 37 хувь суралцах, 41.3 хувь ажиллах (үүнээс 19.1 хувь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 19.6 хувь нь хувиараа ажиллах, 2.6 хувь албан томилолтоор ажиллах), 0.7 хувь эмчлүүлэх, 21.0 хувь бусад зорилгоор хилийн чанадыг зорьжээ.

ЗУРАГ 4.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ЯВСАН ЗОРИЛГО, 2010 ОН



Гадаад явсан зорилгыг хүн амын насны бүлгээр авч үзвэл 15-24 насныхны 72.5 хувь, 25-34 насныхны 35.3 хувь суралцах зорилгоор явсан нь суралцахаар явсан нийт хүний 87.5 хувийг төлөөлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явсан хүний талаас илүү хувийг 25-34 насныхан төлөөлж байгаа бол хувиараа болон албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүсийн дийлэнхийг 35-54 насныхан бүрдүүлж байна (Хүснэгт 4.1). Хөдөлмөрлөх ид 25-44 насныхны 60 хувиас илүү нь ажиллах зорилгоор гадаад орныг зорьж байгааг цаашид анхаарч, тэднийг эх орондоо ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, цалин, орлогыг нэмэгдүүлэх талаар төр засгаас урт, богино хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бага насны хүүхэд, ахмад настны ихэнх нь эмчлүүлэх зорилгоор гадаад орныг зорьж, тэнд 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа нь эх орондоо оношлох, эмчлэх боломж хомс байгаатай холбоотой тул тэдэнд тохиолдож буй өвчнийг оношлох, эмчлэх талаар дорвitoй арга хэмжээ авах шаардлагатай болжээ.

**ХҮСНЭГТ 4.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ЯВСАН ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ,
ХУВИАР, 2010 ОН**

Насны бүлэг	Бүгд	Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
БҮГД	100.0	37.0	19.1	19.6	2.5	0.7	21.0
0-14	100.0	6.9	0.0	0.0	0.0	0.7	92.4
15-24	100.0	72.5	10.5	7.5	0.5	0.3	8.8
25-34	100.0	35.3	29.0	22.2	2.5	0.5	10.5
35-44	100.0	17.8	25.5	34.9	4.5	0.9	16.4
45-54	100.0	6.4	16.3	42.5	8.9	2.3	23.5
55+	100.0	1.6	5.5	33.5	8.3	8.3	42.8
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-14	10.6	2.0	0.0	0.0	0.0	10.6	46.5
15-24	27.6	54.0	15.1	10.6	5.8	9.7	11.5
25-34	35.1	33.4	53.2	39.8	35.1	22.7	17.6
35-44	19.9	9.5	26.5	35.3	35.0	25.0	15.5
45-54	5.6	1.0	4.8	12.2	19.9	17.8	6.3
55+	1.3	0.1	0.4	2.1	4.1	14.2	2.6

Гадаад явсан зорилгыг оршин суугаа улсаар нь авч үзвэл АНУ, БНСУ, БНХАУ-д суралцахаар хамгийн олон хүн (47.8 хувь), БНСУ, БНЧУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар хамгийн олон хүн (76.4 хувь), БНСУ, АНУ-д хувиараа ажиллахаар хамгийн олон хүн (47.3 хувь) явжээ. Эндээс харахад АНУ, БНСУ, БНЧУ монголчууд хамгийн олноороо ажиллаж, амьдарч, сурч байгаа улс болжээ. Харин Энэтхэг болон БНХАУ-д амьдарч байгаа иргэдийн ихэнх нь суралцах зорилгоор явсан байна.


**ХҮСНЭГТ 4.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ЯВСАН ЗОРИЛГО, ОРШИН СУУГАА
УЛС, ХУВИАР, 2010**

Гадаад улс	Бүгд	Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
БҮГД	100.0	37.0	19.1	19.6	2.5	0.7	21.0
БНСУ	100.0	21.6	40.3	22.3	1.8	0.8	13.3
АНУ	100.0	43.6	4.1	19.7	2.2	0.6	29.8
БНЧУ	100.0	9.0	51.6	18.6	1.3	0.2	19.3
БНХАУ	100.0	70.9	3.9	8.1	2.8	0.5	13.9
Япон	100.0	48.3	11.0	13.5	2.4	0.4	24.4
ОХУ	100.0	67.4	3.0	10.4	3.4	0.5	15.2
Герман	100.0	47.8	4.2	12.9	2.4	0.7	31.9
Англи	100.0	55.1	4.0	17.1	1.9	0.2	21.6
Франц	100.0	17.5	8.9	30.3	1.9	4.7	36.7
Турк	100.0	53.6	8.0	30.0	1.1	0.3	7.1
Казахстан	100.0	56.5	5.5	20.2	0.8	1.1	15.9
Унгар	100.0	15.3	38.8	20.2	3.3	0.5	21.9
Швейцари	100.0	22.2	11.2	32.5	5.4	0.7	27.9
Австри	100.0	35.8	6.1	22.5	2.7	0.8	32.0
Канад	100.0	27.5	3.8	19.0	4.4	0.7	44.6
Ирланд	100.0	55.9	3.6	15.4	1.7	0.3	23.2
Энэтхэг	100.0	91.8	0.9	1.3	0.9	0.2	4.9
Бусад	100.0	31.3	10.2	25.2	5.7	0.8	26.8
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
БНСУ	27.6	16.1	58.1	31.3	19.2	29.6	17.5
АНУ	15.9	18.7	3.4	16.0	13.9	13.7	22.6
БНЧУ	6.8	1.6	18.3	6.4	3.4	2.0	6.2
БНХАУ	6.8	13.0	1.4	2.8	7.6	4.3	4.5
Япон	5.0	6.6	2.9	3.5	4.8	2.6	5.9
ОХУ	4.7	8.5	0.7	2.5	6.4	3.3	3.4
Герман	3.6	4.6	0.8	2.4	3.4	3.6	5.5
Англи	3.5	5.1	0.7	3.0	2.7	0.9	3.6
Франц	2.7	1.3	1.2	4.1	2.0	17.1	4.7
Турк	2.5	3.6	1.0	3.8	1.0	0.9	0.8
Казахстан	2.4	3.6	0.7	2.4	0.7	3.7	1.8
Унгар	1.5	0.6	3.1	1.6	2.0	1.0	1.6
Швейцари	1.4	0.8	0.8	2.3	3.0	1.4	1.9
Австри	1.3	1.2	0.4	1.4	1.4	1.4	1.9
Канад	1.2	0.9	0.2	1.1	2.1	1.1	2.5
Ирланд	1.0	1.6	0.2	0.8	0.7	0.4	1.2
Энэтхэг	1.0	2.6	0.0	0.1	0.4	0.3	0.2
Бусад	11.3	9.5	6.0	14.5	25.4	12.6	14.4

ГАДААДАД ОРШИН СУУГАА ХУГАЦАА

Өдгөө монголчуудад гадаад оронд зорчих, амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох өргөн боломж нээгдэж, олон мянган хүн гадаадад түр болон удаан хугацаагаар аж төрж байна. Тэдний гадаад оронд оршин суугаа хугацаа анх явсан зорилго, шалтгаанаас хамаарч харилцан адилгүй юм. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор гадаадад тоологдсон хүн амын 21.5 хувь гадаадад очоод 1 жил хүртэл хугацаанд оршин сууж байгаа бол 53.3 хувь нь 2-5 жил оршин сууж байна. Харин 11-ээс дээш жил гадаадад оршин суугаа иргэд 5.1 хувийг, 6-10 жил оршин суугаа иргэд 19.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 4.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА ХУГАЦААГААР, ХУВИАР,
2010 ОН



Монголчууд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа улс орны тоонд Унгар, Польш, Герман орж байна. Харин Казахстан, БНХАУ-д амьдарч байгаа иргэд хамгийн цөөн жил суугаа ажээ. БНСҮ, БНЧҮ, Австрали, Энэтхэг зэрэг улсад амьдрагчид дунджаар 2-5 жил, Ирланд, АНУ-ын хувьд 6-10 жил суугаа иргэд баагүй хувийг эзэлж байна.

**ХҮСНЭГТ 4.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА ХУГАЦАА,
УЛСААР, 2010 ОН**

Оршин суугаа улс	Тоо	Бүгд хувь	Оршин суугаа хугацаа			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
БҮГД	107 140	100.0	21.5	53.2	19.9	5.4
БНСУ	29 534	100.0	19.6	65.0	12.9	2.4
АНУ	17 036	100.0	14.5	42.3	35.8	7.3
БНЧУ	7 274	100.0	9.7	64.5	18.0	7.8
БНХАУ	7 273	100.0	40.1	51.7	7.4	0.8
Япон	5 401	100.0	22.4	52.6	21.5	3.6
ОХУ	5 008	100.0	34.3	47.6	12.8	5.3
Герман	3 852	100.0	12.1	29.4	39.3	19.3
Англи	3 701	100.0	12.9	51.9	30.1	5.1
Франц	2 859	100.0	21.2	47.0	25.7	6.1
Турк	2 645	100.0	33.8	54.7	10.4	1.2
Казахстан	2 523	100.0	42.4	50.3	6.5	0.8
Унгар	1 615	100.0	8.2	35.4	20.9	35.5
Швейцари	1 509	100.0	22.7	50.4	22.1	4.8
Австри	1 346	100.0	16.9	51.0	25.6	6.5
Канад	1 259	100.0	33.3	44.3	17.8	4.6
Ирланд	1 124	100.0	9.4	48.9	40.7	0.9
Энэтхэг	1 116	100.0	33.9	57.6	7.5	1.0
Польш	999	100.0	15.8	33.6	21.4	29.1
Асвстрали	962	100.0	24.4	58.7	14.7	2.2
Итали	282	100.0	24.5	52.5	15.6	7.4
Бусад	9 822	100.0	26.5	51.2	17.8	4.4

**ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН АЖИЛ
ЭРХЛЭЛТ**


Монгол Улсын иргэд гадаадад ажиллаж байгаа голлох шалтгаан нь өндөр цалин хөлстэй ажил эрхэлж, харьцангуй богино хугацаанд хуримтлал үүсгэж, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилготой нь ойлгомжтой. Гэхдээ суралцах хугацаандaa ажил эрхэлж байгаа хүмүүс нэлээд бий. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор тооллогын товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин орлоготой ажил эрхэлсэн бол ажил эрхэлдэг гэж үзсэн. Гадаадад оршин суугаа 15, түүнээс дээш настай Монгол Улсын нийт иргэдийн 58.6 хувь ажил эрхэлдэг байна.

**ХҮСНЭГТ 4.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ,
ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2010 ОН**

	Бүгд	Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажил эрхэлдэг	58.6	33.5	93.5	82.8	100.0	40.3	56.1
Ажил эрхэлдэггүй	41.4	66.5	6.5	17.2	0.0	59.7	43.9
Эрэгтэй							
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажил эрхэлдэг	64.6	34.8	95.3	86.7	100.0	45.0	62.2
Ажил эрхэлдэггүй	35.4	65.2	4.7	13.3	0.0	55.0	37.8
Эмэгтэй							
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажил эрхэлдэг	53.5	32.6	90.4	79.4	100.0	37.6	52.6
Ажил эрхэлдэггүй	46.5	67.4	9.6	20.6	0.0	62.4	47.4


Ажил эрхэлж буй иргэдийн хүсийн харьцаа тэнцүү байгаа бол ажил эрхэлдэггүй иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна

**ЗУРАГ 4.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС,
ХУВИАР, 2010 ОН**



Хэдийгээр нэлээд тооны хүмүүс гадаадад ажиллахаар явж байгаа боловч тухайн улсдаа очоод ажил олдохгүй, эсвэл хөдөлмөрийн гэрээгээр очсон боловч хөдөлмөрийн хүнд нөхцөл, хувийн сонирхлоос шалтгаалж ажлаас гарах тохиолол цөөнгүй байдаг бололтой (Зураг 4.4). Гэхдээ ажил эрхэлдэггүй хүмүүсийн 68.2 хувь нь суралцах байгаа нь зүй ёсны асуудал юм.

ЗУРАГ 4.4. 15. ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ ИРГЭДИЙН ГАДААД
ЯВСАН ЗОРИЛГО, 2010 ОН




ХҮСНЭГТ 4.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	50.0	50.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	26.5	21.5	31.6	100.0	40.5	59.5
Боловсруулах үйлдвэрлэл	12.1	13.6	10.5	100.0	56.3	43.7
Боловсрол	7.2	5.5	8.9	100.0	38.3	61.7
Барилга	6.0	10.5	1.4	100.0	87.9	12.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.8	2.0	5.7	100.0	26.1	73.9
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3.8	3.2	4.4	100.0	41.8	58.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	2.9	3.1	2.7	100.0	53.8	46.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.5	3.8	1.3	100.0	74.8	25.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	2.5	3.0	1.9	100.0	62.0	38.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	2.4	3.3	1.6	100.0	68.2	31.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон тенхникийн үйл ажиллагаа	2.4	2.6	2.1	100.0	54.6	45.4
Үрлаг, үзвэр, тоглоом наадам мэдээлэл, холбоо	1.8	1.7	1.9	100.0	47.4	52.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.8	2.2	1.4	100.0	61.7	38.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.5	1.0	2.0	100.0	33.2	66.8
Хүн хөлсөлж ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1.3	1.9	0.6	100.0	75.8	24.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.7	0.6	0.7	100.0	45.3	54.7
Үул уурхайн олборлолт	0.6	0.9	0.2	100.0	79.3	20.7
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.5	0.3	0.6	100.0	34.0	66.0
Усан хангамж, бохир ус, хог, хаягдын менежмент болон цэв	0.3	0.4	0.2	100.0	61.8	38.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.3	0.3	0.3	100.0	47.1	52.9
Салбар заагдаагүй	18.5	18.0	19.0	100.0	48.8	51.2

Монголчууд хамгийн олноор суурьшсан БНСҮ, БНЧҮ, АНҮ-д ажиллаж байгаа иргэд ихэвчлэн үйлчилгээний болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Мөн боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа манай улсын иргэд АНҮ-д цөөнгүй байна.

**ЗУРАГ 4.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗАРИМ УЛС, ХУВИАР, 2010 ОН**




Гадаадад ажиллаж, суралцаж байгаад эх орондоо буцаж ирсэн иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох боломжгүйгээс буцаад гадаадад гарах тохиолдол цөөнгүй байдаг талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэлээд бичих болсон. БНЧУ-аас ирсэн нэгэн бичихдээ: “Би эрхзүйч мэргэжилтэй, нөхөр зураач. Бид хоёр БНЧУ улсад 3 жил болоод одоо Монголдоо ирээд 3 сар болж байна. Хүүгээ нэг настай байхад орхиод явсан, ирээд цэцэрлэгт оруулчихаад л... Амьхандаа нутагтаа суурьшихаар шийдэн ажлын эрэлд гарч, 30 гаруй байгууллагад ажилд орох өргөдлийн маягт бөглөсөн боловч, ажилд авах газар олддоггүй ээ. Нөхөр маань аргаа бараад буцаад явсан. Би ч бас буцах тийшээгээ хандах болж байна. Төр засаг гадаадад олон жил болсон биднийгээ иймэрхүү л хүлээж авч байна шүү дээ. Бидний адил Монголдоо ажиллаж, амьдрах орон зайгаа олохгүй, эргээд гадагшаа гарч байгаа гэр бүл олон бий гэж бодож байна. Ганц хүүгээ дахиад л хүлээхийн, ганцаардахын “өнчрөлд” үлдээгээд явлаа даа. Бид бүгд эх орон, ээж аав, үр хүүхдээ ямар их санаж ирлээ. Нийгмийн буруу тогтолцооноос болоод сайхан сэтгэл, итгэл өвөрлөж ирсэн бүхэн бараг буцаж байна даа...”⁵ хэмээн бичсэн нь үүнийг гэрчлэх нэгэн баримт гэлтэй. Засгийн газраас “Зөгийн үүр” хөтөлбөр боловсруулж, нэлээд ажлыг хийж эхэлж байна. Нарийн мэргэшсэн, дадлага, туршлагатай ажиллагчдаа авч ирэх, ажиллах боломжийг бүрдүүлэх талаар энэ хөтөлбөрийн хүрээнд нэлээд ажил хийж эхэлж байгаа нь сайшаалтай. Цаашдаа хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын багцад гадаадад оршин суугаа монгол гэр булийн байдал, тэдний нүүдэл, суудлын эргэлтэнд орох магадлал, Монгол Улсынхаа хөгжилд оруулах бодит хувь нэмэр зэргийг нарийвчлан судалж, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, төрөөс баримтлах нийгмийн бодлогод тусгах шаардлага тулгарч байна.

⁵ www.MGLCZ.com, 2010.05.15

ТАВЛУГААР БУЛЭГ

ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН МОНГОЛ ДАХЬ ГЭР БУЛИЙН
ГИШҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ



Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийг интернетээр тоолох асуулга (Маягт ХАОСТ-1.2) –д тэдний Монгол дахь гэр бүл, тэдгээрийн орон сууцтай холбоотой ямар нэг мэдээлэл тусгагдаагүй талаар өмнө дурдсан. Тиймээс гадаадад оршин суугаа иргэдийн Монгол дахь ар гэрийнхнээс (Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулгын маягт ХАОСТ-1 –ээр) нь асууж цуглуулсан мэдээллийг үндэслэн өрхийн гишүүдийн эдийн засгийн идэвх, орон сууцны нөхцөл байдлыг гадаадад гэр бүлийн гишүүн амьдардаггүй өрхийнхтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

ГАДААДАД ОРШИН СУУГАА АМ БУЛИЙН ГИШҮҮНТЭЙ ӨРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулга, Маягт ХАОСТ-1-ийн мэдээллээр 40.4 мянган өрхийн 62.9 мянган иргэн гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар сууж байгаа дүн гарчээ (Хүснэгт 5.1).


ХҮСНЭГТ 5.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ӨРХИЙН АМ БУЛИЙН ТООГООР, 2010

Өрхийн ам булийн тоо	Гадаадад суугаа хүнтэй өрхийн тоо	Гадаадад суугаа өрхийн гишүүдийн тоо											Өрхийн нийт гишүүдээс гадаадад байгаа хүний тоо
		1	2	3	4	5	6	7	8	9	10+		
БҮГД	40 388	27941	7038	2 833	1 474	605	280	88	60	25	37		62 870
1	3 290	2 028	641	326	178	65	30	13	5	3	1		5 673
2	8 548	5 885	1 501	603	302	141	69	15	13	7	12		13 431
3	10 067	7 325	1 600	616	305	125	52	19	19	2	4		14 877
4	7 858	5 590	1 323	470	278	113	52	14	7	3	8		11 907
5	4 948	3 410	853	367	180	72	33	14	4	7	8		7 779
6	2 998	1 979	586	234	116	44	22	8	7	1	1		4 803
7	1 398	935	268	94	63	22	7	2	4	1	2		2 232
8+	1281	793	268	124	52	23	15	3	1	1	1		2168

Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар оршин сууж буй хүнтэй өрхийн 76.1 хувь буюу 30.7 мянга нь Улаанбаатар хотынх байна.

Гадаадад оршин сууж буй өрхийн гишүүний тоогоор нь авч үзвэл нийт өрхийн 69.2 хувь буюу 27.9 мянган өрхөөс нэг хүн, 17.4 хувь буюу 7.0 мянган өрхөөс хоёр хүн, 7.0 хувь буюу 2.8 мянган өрхөөс гурван хүн, 3.6 хувь буюу 1.5 мянган өрхөөс дөрвөн хүн, 2.8 хувь буюу 0.6 мянган өрхөөс таваас дээш хүн нь гадаадад сууж байна (Зураг 5.1).

**ЗУРАГ 5.1. ГАДААДАД СУУГАА ХҮНТЭЙ ӨРХИЙН БҮТЭЦ, ГАДААДАД БУЙ ХҮНИЙ
ТООГООР, ХУВИАР, 2010**



Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар суудаг хүнтэй дөрвөн өрхийн нэг нь гурван ам бүлтэй, таван өрхийн нэг нь дөрвөн ам бүлтэй, арван өрхийн нэг нь нэг ам бүлтэй байна.


Монгол Улсын нийт өрхийн 6 орчим хувь нь гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар ажиллаж, амьдарч буй гишүүнтэй бөгөөд ам булийн тоогоор нь авч үзвэл нэг, дөрөв, таван ам бүлтэй өрх улсын дунджаас бага буюу 4.3-4.8 хувийг, гурав, зургаан ам бүлтэй өрх улсын дунджид, хоёр болон долоон ам бүлтэй өрх 7.5 хувийг эзэлж байна. Харин наймаас дээш ам бүлтэй арван өрхийн нэг нь гадаадад оршин суугаа гишүүнтэй дүн гарчээ (Хүснэгт 5.2).

ХҮСНЭГТ 5.2. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН АМ БУЛИЙН ТООГООР, 2010

Өрхийн ам булийн тоо	Нийт өрхийн тоо	Гадаадад суугаа хүнтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь	Дүнд эзлэх хувь		Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрх
			Нийт өрх	Гадаадад суугаа гишүүнтэй өрх	
БҮГД	713 780	5.6	100.0	100.0	
1	75 917	4.3	10.6	8.1	
2	114 642	7.5	16.1	21.2	
3	165 873	6.1	23.2	24.9	
4	171 733	4.6	24.1	19.5	
5	103 933	4.8	14.6	12.3	
6	50 085	6.0	7.0	7.4	
7	18 601	7.5	2.6	3.5	
8 +	12 996	9.9	1.8	3.1	

Гадаадад оршин суугаа гишүүнтэй дөрвөн өрхийн нэг нь гурван ам бүлтэй, таван өрхийн хоёр нь хоёр болон дөрвөн ам бүлтэй байна. Харин гадаадад оршин суугаа гишүүнтэй нийт өрхийн 8.1 хувийг нэг ам бүлтэй, 12.3 хувийг таван ам бүлтэй, 7.4 хувийг зургаан ам бүлтэй, 3.5 хувийг долоон ам бүлтэй, 3.1 хувийг найм ба түүнээс дээш ам бүлтэй өрх эзэлж байна (Зураг 9). Монгол Улсын нийт өрхийн 21.5 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байдаг. Гэтэл гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн 33.3 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа нь улсын дунджаас 11.8 пунктээр илүү юм.

**ЗУРАГ 5.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ ӨРХИЙН АМ БҮЛИЙН БҮТЭЦ,
ХУВИАР, 2010**



Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн 92.9 хувь буюу 37.5 мянга нь хотод, 7.1 хувь буюу 2.9 мянга нь хөдөө амьдарч байна.

**ХҮСНЭГТ 5.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨРХИЙН ГИШҮҮДИЙН БҮТЭЦ, МОНГОЛ ДАХЬ
ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ХУВИАР, 2010**

Өрхийн ам бүлийн тоо	Гадаадад суугаа гишүүдийн дүн	Өрхийн тэргүүлэгчийн хамаарлаар									
		Эхнэр, нөхөр	Хүү, охин	Эцэг, эх	Ах, эгч, дүү	Хадам эцэг, эх	Хүргэн, бэр	Өвөг эцэг, эмэг	Ач, Зээ	Бусад	
БҮГД	100.0	6.7	53.0	2.1	10.2	0.4	6.5	0.1	11.3	9.8	
1	100.0	8.2	48.7	5.6	12.0	0.1	4.8	0.1	13.4	7.0	
2	100.0	8.9	55.9	2.2	7.9	0.2	5.4	0.0	14.0	5.5	
3	100.0	9.6	55.9	1.9	8.5	0.5	5.5	0.0	10.1	7.9	
4	100.0	5.6	52.5	1.9	10.9	0.5	6.6	0.1	9.9	11.9	
5	100.0	3.3	50.1	1.2	12.5	0.5	7.8	0.0	9.7	14.9	
6	100.0	2.7	49.6	1.2	13.2	0.7	8.7	0.0	10.8	13.1	
7	100.0	2.3	52.3	0.8	11.4	0.4	9.7	0.0	10.5	12.5	
8 +	100.0	1.4	47.0	0.5	11.8	0.4	11.4	0.0	12.1	15.4	


Гадаадад оршин суугаа өрхийн гишүүдийг Монголд байгаа өрхийн тэргүүлэгчийн хамаарлаар нь авч үзвэл гадаадад амьдралж нийт хүний 53.0 хувь буюу 33.3 мянга нь хүү, охин, 11.3 хувь буюу 7.1 мянга нь ач, зээ, 10.2 хувь буюу 6.4 мянга нь ах, эгч, дүү, 6.7 хувь буюу 4.2 мянга нь эхнэр, нөхөр, 6.5 хувь буюу 4.1 мянга нь хүргэн, бэр байна.

Хот, хөдөөгөөр бол хотын өрхөөс гадаадад амьдарч гишүүдийн өрхийн тэргүүлэгчийн хамаарал нь улсын дундажтай ойролцоо байхад харин хөдөөний өрхөөс гадаадад амьдарч буй арван хүн тутмын нэг нь хүү, охин нь байна.

Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа гишүүдийн 23.7 хувь нь гурван ам

бүлтэй, 21.4 хувь нь хоёр ам бүлтэй, 18.9 хувь нь дөрвөн ам бүлтэй, 12.4 хувь нь таван ам бүлтэй өрхөд тус тус амьдарч байсан байна (Зураг 5.3).

**ЗУРАГ 5.3. ГАДААДАД СУУГАА ХҮНИЙ МОНГОЛ ДАХЬ ӨРХИЙН АМ БҮЛИЙН БҮТЭЦ,
ХУВИАР, 2010**



1-3 ам бүлтэй өрхөөс суралцахаар гадаад явсан хувь олон ам бүлтэй өрхийнхөөс илүү байхад, олон ам бүлтэй өрхийн хөдөлмөрийн гэрээгээр болон хувиараа ажиллах зорилгоор явсан хүний эзлэх хувь харьцангуй өндөр байна. Харин албан томилот болон эмчлүүлэхээр явсан хүний эзлэх хувь бүх өрхөд ойролцоо байна /Хүснэгт 5.5/.

**ХҮСНЭГТ 5.4. ГАДААДАД СУУГАА ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ТОО, ГАДААД ЯВСАН ЗОРИЛГО,
АМ БҮЛИЙН ТООГООР, ХУВИАР, 2010**

Өрхийн ам бүлийн тоо	Гадаадад суугаа өрхийн гишүүдийн дүн	Гадаад явсан зорилго					
		Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
1	9.0	8.9	6.8	9.0	13.1	15.0	11.8
2	21.4	22.9	19.2	20.2	24.6	19.7	22.5
3	23.7	26.1	24.0	21.9	21.5	20.4	20.9
4	18.9	18.7	19.4	19.1	17.8	17.3	18.8
5	12.4	11.9	13.1	12.9	10.6	10.0	12.0
6	7.6	6.2	8.8	8.7	5.8	9.7	7.6
7	3.6	3.0	4.1	4.2	3.0	4.4	3.0
8 +	3.4	2.3	4.8	4.0	3.5	3.5	3.4


Эрэгтэй тэргүүнтэй өрхөөс суралцахаар явсан хүний нийт дүнд эзлэх хувь 38.7 байгаа нь Эмэгтэй тэргүүнтэй өрхтэй харьцуулахад 9.3 пунктээр илүү байна. Харин эмэгтэй тэргүүнтэй өрхөөс хөдөлмөрийн гэрээгээр болон хувиараа ажиллахаар явсан хүний нийт

дүнд эзлэх хувь нь эрэгтэй тэргүүнтэй өрхийнхөөс харьцангуй өндөр буюу 24.8-28.9 (эрэгтэй тэргүүнтэй өрхийнх 18.4-25.2) хувьтай байна.

Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар оршин суугаа гишүүнтэй өрхийн нийт хүн амын 21.5 хувь буюу 31.4 мянга нь 0-14 насны хүүхэд, 67.0 хувь буюу 97.8 мянга нь 15-59 насны хүн ам, 11.5 хувь буюу 16.8 мянга нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр гарсан Монгол Улсын нийт хүн ам болон гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа гишүүнтэй өрхийн хүн амын насны бүтцийг Зураг 5.4-д харуулав.

ЗУРАГ 5.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ХУВИАР, 2010



Энэ зургаас харахад гадаадад өрхийн хэн нэг нь суудаг өрхөд хөдөлмөрийн насны буюу 15-59 насны хүн амын эзлэх хувь улсын дундажтэй ижил байхад, 0-14 насны хүүхдийнх 21.5 хувь байж, улсын дунджаас 5.8 пунктээр бага, харин тэтгэврийн насны буюу 60, түүнээс дээш насны хүний эзлэх хувь улсын дунджаас 6 пунктээр илүү байна.

ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ХҮНТЭЙ ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

Үндэсний тооцооны системийн хүрээнд тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа ажиллагч, ажиллахад бэлэн байгаа ажилгүй иргэнийг эдийн засгийн идэвхтэй хүн амд хамруулдаг⁶. Эдийн засгийн идэвхтэй хүн амгийг байнгын болон тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилдаг. Тооллогоор тухайн үеийн эдийн засгийн идэвхээр тодорхойлж гаргасан байна.

6 “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хучний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”, УСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал, 2009 он


ХҮСНЭГТ 5.5. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, 2010

	Нийт хүн ам	Гадаадад суугаа хүнтэй өрхийн хүн ам
15, түүнээс дээш насны хүн ам	100.0	100.0
Үүнээс:		
Эдийн засгийн идэвхтэй хүн ам - Бүгд	56.4	47.9
Ажил эрхэлдэг	47.8	41.5
Ажил хайж байгаа	8.6	6.4
Эдийн засгийн идэвхгүй хүн ам - Бүгд	43.6	52.1
Сургуульд сурдаг	15.8	17.0
Тэтгэвэрт	10.1	18.9
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	2.9	2.9
Гэрийн ажилтай	5.6	5.0
Тохирох ажил олдохгүй байгаа	6.4	5.3
Ажиллах сонирхолгүй	0.2	0.2
Бусад	2.6	2.8

Эдийн засгийн идэвхтэй хүн амд сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон эсвэл тогтмол ажил эрхэлдэггүй боловч тооллогын товын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн болон ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүмүүсийг хамруулсан. Харин сүүлийн 7 хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаarahгүй хүнийг эдийн засгийн идэвхгүй хүн ам⁷ гэж үзнэ.

Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар сууж буй гишүүнтэй өрхийн нийт хүн амын 78.5 хувь нь 15, түүнээс дээш насны хүмүүс байна. Эдгээр хүмүүсийн 47.9 хувь нь эдийн засгийн идэвхтэй, 52.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн байна.

ЗУРАГ 5.5. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМ, ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ ЭСЭХ, ХУВИАР, 2010 ОН




⁷ “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчиний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”, УСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал, 2009 он

Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн амын 86.7 хувь нь ажил эрхэлж, 13.3 хувь нь ажил хайж байна. 15, түүнээс дээш насны нийт хүн ам болон гадаадад оршин суугаа хүнгүй өрхөөс ажил эрхэлж буй хүн нь 2 пунктээр илүү, харин ажил хайж байгаа нь 2 пунктээр бага байна. Ер нь нийт хүн ам болон гадаадад өрхийн гишүүн нь амьдардаггүй өрхийн бүтцийн үзүүлэлт ойролцоо гарч байгаа тул цаашид зөвхөн гадаадад хэн нэг нь амьдардаггүй өрхийн гишүүдтэй харьцуулж харуулах болно.

Гадаадад суугаа хүнтэй өрхийн 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй нийт хүн амын 32.7 хувь нь суралцаж, 36.3 хувь нь тэтгэвэрт, 9.7 хувь нь гэрийн ажилтай, 5.6 хувь хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэх чадваргүй, 10.1 хувь нь тохирох ажил олдохгүй, 0.3 хувь нь ажиллах сонирхолгүйгээс ажил эрхлээгүй хүмүүс байна.

Гадаадад суугаа хүнтэй өрхийн 15, түүнээс дээш насны нийт хүн амд эзлэх эдийн засгийн идэвхгүй хүн амын хувь нь улсын дунджаас (улсын дундаж 43.6 хувь) харьцангуй өндөр байгаад тухайн өрхийн нийт хүн амд 60 ба түүнээс дээш насны хүн ам буюу тэтгэвэрт байгаа хүний эзлэх хувь өндөр байгаатай холбоотой.

ЗУРАГ 5.6. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ, ШАЛТГААН, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн ам бүлээс ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг гадаадад оршин суугаа гишүүнгүй өрхийн ам булийнхтэй харьцуулж үзэхэд (Зураг 5.6) гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхөд тэтгэвэрт байгаа хүмүүсийн эзлэх хувь харьцангуй өндөр (36.3 хувь байгаа буюу 14.2 пунктээр илүү), харин бусад шалтгааны эзлэх хувь гадаадад оршин суугаа гишүүнгүй өрхөөс 0.1-4.9 пунктээр бага байна.

Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн 15, түүнээс дээш насны хүмүүсийн ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг хот, хөдөөгөөр (Зураг 5.7) авч үзвэл хотын өрхийн сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай болон бусад шалтгаантай хүний нийт хүнд эзлэх хувь хөдөөгийнхөөс 0.6-9.1 пунктээр илүү байхад тэтгэвэрт, хөдөлмөр эрхлэх чадваргүй, эсвэл

ажиллах сонирхолгүй шалтгаантай хүний эзлэх хувь хотод хөдөөнийхөөс 0.1-4.5 пунктээр бага байна. Хөдөөд тохиорох ажил олдохгүй шалтгаанаар ажил эрхлээгүй хүмүүс 13.8 хувийг эзэлж байгаа нь хотынхоос 3.9 пунктээр илүү байна.

ЗУРАГ 5.7. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ ӨРХИЙН 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ХҮМҮҮС, ШАЛТГААН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад амьдарч буй ам бүлийн гишүүнтэй эрэгтэй тэргүүнтэй өрхийн 15, түүнээс дээш насын хүн амын 49.6 хувь нь эдийн засгийн идэвхтэй, 50.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй байхад эмэгтэй тэргүүнтэй өрхийн 43.7 хувь нь эдийн засгийн идэвхтэй, 56.3 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна.

ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ

Гадаадад оршин суугаа гишүүнтэй нийт өрхийн 12.0 хувь гэрт, 87.5 хувь байшинд, 0.5 хувь зориулалтын бус сууцанд амьдарч байна (Хүснэгт 5.7).


Монгол Улсын нийт өрхийн 45.2 хувь нь гэрт, 53.6 хувь нь байшинд амьдарч буй дүнтэй харьцуулахад үзэхэд гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн гэрт амьдардаг өрхийн нийт дүнд эзлэх хувь нь улсын дүнгээс харьцангуй бага, харин байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь улсын дүнгээс харьцангуй өндөр буюу 33.9 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, гадаадад хэн нэг гишүүн нь амьдардаг өрхийн дийлэнх нь байшинд амьдарч байна.

ХҮСНЭГТ 5.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010

Сууцны төрөл	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	40 388	100.0	37 491	100.0	2 897	100.0
Гэр	4 843	12.0	3 863	10.3	980	33.8
Байшин	35 323	87.5	33 431	89.2	1 892	65.3
Зориулалтын бус сууц	222	0.5	197	0.5	25	0.9

Гадаадад суугаа хүнтэй хотын арван өрхийн нэг нь гэрт, ес нь байшинд амьдарч байхад хөдөөгийн арван өрхийн турав нь гэрт, зургаа нь байшинд, нэг нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.


ЗУРАГ 5.8. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ БОЛОН ГИШҮҮНГҮЙ ӨРХ, ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН



Гадаадад оршин суугаа гишүүнтэй өрхийн сууцны төрлийг гадаадад оршин суугаа гишүүнгүй өрхтэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь харьцангуй өндөр харагдаж байна. Ер нь гадаадад амьдарч байгаа өрхийн гишүүдийн бараг хоёр хүний нэг нь хөдөлмөрийн гэрээгээр болон хувиараа ажиллах зорилгоор гадаад явсан болохоор эдгээр хүмүүс өрхийн орон сууцны нөхцөл байдлаа дээшлүүлсэн байх магадлалтай гэж үзэхээр байна.

Өрхийн амьдарч буй байшингийн сууцны зориулалтаар нь авч үзэхэд гадаадад оршин суугаа гишүүнтэй арван өрхийн зургаа нь орон сууцны байшинд, дөрөв нь сууцны тусдаа байшинд амьдарч байна. Харин бусад сууцны зориулалтын байранд нийт өрхийн дөнгөж 3.6 хувь нь амьдарч байна (Зураг 5.9).

**ЗУРАГ 5.9. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГИШҮҮНТЭЙ БОЛОН ГИШҮҮНГҮЙ ӨРХ,
БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010**



Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар оршин суугаа гишүүнтэй болон гишүүнгүй өрхийн амьдарч буй байшингийн зориулалтыг нийт дунд эзлэх хувиар нь харьцуулахад орон сууцны байшин болон бие даасан тохилог сууцанд гадаадад ажиллаж, сурч, амьдарч буй ам бүлтэй өрхийн эзлэх хувь гадаадад хэн нэг хүн нь амьдардаггүй өрхийнхөөс харьцангуй өндөр байна. Тухайлбал, бие даасан тохилог сууцанд амьдардаг гадаадад оршин суугаа ам бүлтэй өрхийн эзлэх хувь гадаадад оршин суугаа хүнгүй өрхөөс 2 дахин их, харин орон сууцны байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 22.8 пунктээр илүү байна. Ийнхүү амьдарч буй байшингийн зориулалтаас үзэхэд гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар амьдарч байгаа ам бүлтэй өрхийн орон сууцны нөхцөл нь гадаадад суугаа хүнгүй өрхөөс сайн байна гэж хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл, гадаадад оршин суугаа ам булийн ихэнх нь ажиллахаар явсан нь өрхийнхөө орон сууцны нөхцөлийг сайжруулах зорилготой байсан байна гэж дүгнэж болохоор байна.

ГАДААДАД АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ХУРААНГУЙ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ





ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ХУРААНГУЙ

Монгол Улсын нэр хүнд олон улсын хэмжээнд өсч, гадаад харилцаанд таатай, найрсаг орчин бурдэхийн хэрээр монголчууд гадаад оронд зорчих, оршин суух, ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох өргөн боломжийг олж, олон мянган хүн гадаад оронд түр болон удаан хугацаагаар аж төрж байна. Манай улсанх удаагаа гадаадад суугаа иргэдээ интернэтээр болон ар гэрийнхнээс нь асууж лавлах, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газарт ирүүлж, маягт нөхүүлэх замаар тооллоо. Тооллогын дүнгээс үзвэл Монгол Улсын 107140 иргэн 6 сараас дээш хугацаагаар гадаад оронд ажиллаж, сурч, амьдарч байна. Энэ нь Монголын нийт хүн амын 4 хувь болно. Гадаадад тоологдсон иргэдийн 50.0 мянга нь эрэгтэйчүүд, 57.2 мянга нь эмэгтэйчүүд ба тэдний 53.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүсийн харьцаагаар авч үзвэл гадаадад амьдрагчдын нас ахих тутам эрэгтэйчүүдийн тоо багасч байна. Гадаадад суугаа иргэдийн 82.5 хувийг ид ажиллах, сурч боловсрох 15-44 насныхан эзэлж байна. Харин 45-64 насныхан 6.6 хувь, 0-14 насны хүүхэд багачууд 10.6 хувийг эзэлж байна.

Гадаадад очсон зорилгоор нь үзвэл 37.0 хувь нь суралцах, 41.3 хувь нь хөдөлмөр эрхлэх, 0.7 хувь нь эмчлүүлэх, 21.0 хувь нь бусад зорилгоор явжээ. Тэгэхдээ АНУ, БНСҮ, БНХАУ-д суралцахаар, БНСҮ, БНЧУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар, БНСҮ, АНУ-д хувиаараа ажиллахаар явж удаан хугацаагаар суурьшин ажиллаж амьдарч байна. Энэ нь Монгол Улс, гадаадын улс орны хооронд байгуулсан гэрээ хэлцэл, гадаад орнуудын сурх, ажиллах нөхцөл боломжоос шалтгаалж байна. Гадаадад оршин суугаа иргэдийн ихэнх нь нийслэл Улаанбаатар хот болон мэдээлэл, харилцаа сайн хөгжсөн аймаг, орон нутгаас явсан байна. Тухайлбал: 80 хувь нь Улаанбаатараас, 7 хувь нь Дархан-Уул, Орхон, 2.6 хувь нь Баян-Өлгий аймгаас явсны гадна Сэлэнгэ, Төв аймгаас явсан хүний too харьцангуй өндөр хувь эзэлж байна. БНСҮ, АНУ, БНЧУ, БНХАУ, Япон, ОХҮ-д монголчууд олноор ажиллаж амьдарч байна. Эдгээр улсад гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн 66.8 хувь нь ажиллаж, сурч, амьдарч байна. Гадаадад буй иргэдийг оршин суугаа тивээр нь авч үзвэл 20 орчим хувь нь АНУ тивд, 47.5 хувь нь зүүн Ази, Номхон далайн бүс нутагт, 31.3 хувь нь Европд зорчсон бол зүүн бүсээс өмнөд Ази, Европд, баруун бүсээс зүүн Ази, Номхон далайн бүс нутагт явсан хүмүүс харьцангуй олон байна.

Гадаадад суугаа иргэдийн 87.7 хувь нь Халхчууд, 1.5 хувь нь Казахууд, 1.9 хувь нь Буриадууд байна. Гадаадад монголын бүх угсаатны төлөөлөл амьдарч байна

Боловсролын байдлыг авч үзвэл гадаадад суугаа 10 ба түүнээс дээш настай иргэдийн 38.4 хувь нь бүрэн дунд боловсролтой, 34.6 хувь нь бакалаврын боловсролтой, 11.7 хувь нь магистр, докторын зэрэг хамгаалсан хүн байна. Гадаадад оршин суугчдын 70 гаруй хувийг бүрэн дундаас дээш боловсролтой хүмүүс эзэлж байгаа нь Монголын оюунлаг, боловсролтой иргэдийн нилээд хувь нь гадаадад ажиллаж, амьдарч байна гэсэн үг юм.

Гадаадад суугаа иргэдийн 37.9 хувь нь гэр бүл болж баталгаажуулсан байна. Харин 46.6 хувь нь огт гэр бүл болоогүй байгаа нь анхаарал татсан асуудал юм. Ид амьдрал зохиож, гэр бүл төлөвлөх 25-34 насныхны 37.9 хувь нь огт гэр бүл болоогүй байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Гэхдээ энэ нь залуучуудын гэр бүл болох нас хойшилж байгаа нийтлэг жишигтэй холбоотой байж болох юм. Харин 35-54 насныханд гэр бүлээ тусгаарласан, цуцалсан хүний хувийн жин харьцангуй өндөр байгаа нь гэр бүлийн нэг хүн гадаад явахад гэр бүл тогтвортгүй байдалд орж байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

Гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн 58.6 хувь нь ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхэлж байгаа дүн тооллогоор гарлаа. БНСҮ, БНЧУ, АНУ-д иргэд ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Эдгээр улсад байгууллагын гишүүнчлэлтэй

холбоотой болон компьютерийн, хувь хүн, өрхийн хэрэглээний барааны засвар үйлчилгээг хамарсан “үйлчилгээний бусад салбар”-т ажиллагчид нэлээд олон байна. Барилга, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, байр орон сууц, хоол, хүнс, агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг салбарт Монголчууд ажиллаж байна. ХАА, ан агнуур, ойн аж ахуйд ч цөөнгүй хүмүүс ажиллаж байна.

Гадаад оронд гэр бүлийн хүн нь амьдардаг нийт өрхийн 69.2 хувиас нь өрхийн нэг хүн, 17.4 хувиас нь өрхийн хоёр хүн, 7.0 хувиас нь өрхийн гурван хүн, 3.6 хувиас нь өрхийн дөрвөн хүн, 2.8 хувиас нь өрхийн 5, түүнээс дээш хүн амьдарч байна. Гадаадад сууж байгаа ам бүлтэй арван өрхийн найм нь Улаанбаатар хотын өрх, гурван өрхийн нэг нь эмэгтэй тэргүүнтэй өрх байна. Монголд суугаа өрхийн тэргүүний хамаарлаар авч үзэхэд гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар сууж байгаа хоёр хүний нэг нь тухайн өрхийн тэргүүний хүүхэд нь байна.

Гадаад оронд суугаа ам бүлтэй өрхийн нийт хүн амын 21.5 хувь нь 0-14 насын хүүхэд, 67.0 хувь нь 15-59 насын хүн, 11.5 хувь нь 60, түүнээс дээш насын хүмүүс байна. Монгол Улсын нийт хүн ам болон гадаадад хэн нэг хүн нь амьдардаггүй өрхийн хүн амын насын бүтэцтэй харьцуулан авч үзэхэд гадаадад суугаа ам бүлтэй өрхөд амьдарч буй 0-14 насын хүүхдийн эзлэх хувь бага, 60, түүнээс дээш насын хүн амын эзлэх хувь харьцангуй өндөр байна. Гадаадад тухайн өрхийн хөдөлмөрийн насын залуучууд суралцаж, ажиллаж амьдарч байгаатай холбоотой байна.

Гадаадад оронд суугаа ам бүлтэй нийт өрхийн 12.0 хувь нь гэрт, 87.5 хувь нь байшинд, 0.5 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна. Өрхийн сууцны төрлийг гадаадад суугаа хүнгүй өрхтэй харьцуулан үзэхэд байшинд амьдарч буй гадаадад сууж байгаа хүнтэй өрхийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Өрхийн амьдарч буй байшингийн сууцны зориулалтаар нь авч үзвэл гадаадад суугаа өрхийн ам бүлтэй арван өрхийн зургаа нь орон сууцны байшинд, дөрөв нь сууцны тусдаа байранд амьдарч байна. Бие даасан тохилог орон сууцанд сууж буй өрхийн нийт дунд эзлэх хувь бага ч гэсэн гадаадад оршин суугаа хүнгүй өрхийнхөөс 2 дахин өндөр байна.

Гадаадад 6 сар, түүнээс дээш хугацаагаар амьдрал сууж байгаа хүнтэй өрхийн орон сууцны нөхцөл байдал гадаадад оршин суугаа хүнгүй өрхөөс сайн байгаа нь тэдгээр өрхийн дийлэнх нь байшинд тэр тусмаа орон сууцны байшинд амьдарч байгаагаар илэрч байна. Гадаадад сууж байгаа хоёр хүний нэг нь хөдөлмөрийн гэрээ болон хувиараа ажиллахаар гадагшаа явсан нь өрхийнхөө орон сууцны нөхцөлийг сайжруулах боломжийг бүрдүүлж байна.

ГАДААД ОРОНД АМЬДРАН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД УЧИРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

